



Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газар

**ДОТООД АУДИТЫН ЧИГ ҮҮРГИЙГ БҮРЭН  
ХЭРЭГЖҮҮЛЭЭЛЭХЭД АНХААРАХ  
ШААРДЛАГАТАЙ БАЙНА**

**АУДИТЫН СЭДЭВ: ТӨРИЙН  
БАЙГУУЛЛАГУУДЫН ДОТООД АУДИТЫН  
ТОГТОЛЦОО, ЧИГ ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТ**

**АУДИТЫН КОД: ДГА-2021/15-9-ШТА-ГА**

Дорноговь аймаг  
2021 он

Дарга, тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий  
Утас: 70522734 Цахим хаяг: [ganulziit@audit.gov.mn](mailto:ganulziit@audit.gov.mn)

Аудитын менежер: У.Оюунтүлхүүр  
Утас: 70523020 Цахим хаяг: [oyuntulkhuur.u@audit.gov.mn](mailto:oyuntulkhuur.u@audit.gov.mn)

Аудитор: Б.Уранбилэг  
Утас: 70523020 Цахим хаяг: [uranbileg.b@audit.gov.mn](mailto:uranbileg.b@audit.gov.mn)

Аудитор: Л.Равдандорж  
Утас: 70523020 Цахим хаяг: [ravdandorjl@audit.gov.mn](mailto:ravdandorjl@audit.gov.mn)

## АГУУЛГА:

|                                                                            |   |
|----------------------------------------------------------------------------|---|
| Товчилсон үгийн тайлбар .....                                              | 2 |
| Товьёг .....                                                               | 3 |
| Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл ..... | 4 |

## БҮЛЭГ 1: ДОТООД АУДИТЫН НЭГЖИЙН ТОГТОЛЦОО ОНОВЧГҮЙ БАЙНА.

1.1 Дотоод аудитыг хэрэгжүүлэхтэй холбоотой эрх зүйн орчин бүрдсэн байна.

1.1.1 Дотоод аудитын үйл ажиллагааг зохицуулах эрх зүйн баримт бичгүүд батлагдсан байна..

1.1.2 Стандартад заасны дагуу дотоод аудитын нэгжийн дүрмийн зарим шаардлага тусгагдаагүй байна.

1.2 Дотоод аудитын нэгж нь чиг үүргээ бүрэн хэрэгжүүлэх боломжтой бүтэц, хөрөнгөөр хангагдсан боловч мэргэжлийн хүний нөөц дутагдалтай байна.

1.2.1. Дотоод аудитын чиг үүргийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд аймаг орон нутгаас дэмжиж ажилласан байна

1.2.2. Хөндлөнгийн нөлөөлөлгүй, хараат бусаар ажиллах нөхцөл бүрэн бүрдээгүй байна.

1.2.3. . Хүний нөөцийн хүрэлцээгүй байгаагаас зарим ажилчид дотоод аудитын дүрэмд заасан шалгуурыг хангаагүй.

## БҮЛЭГ 2: ДОТООД АУДИТЫН НЭГЖ ХОЛБОГДОХ ХУУЛЬ ТОГТООМЖИД ЗААСАН ЧИГ ҮҮРГИЙГ БҮРЭН ХЭРЭГЖҮҮЛЭЭГҮЙ БАЙНА.

2.1 Санхүүгийн хяналт шалгалтад илүү анхаарч дотоод аудитын чиг үүргийг орхигдуулсан байна.

2.1.1 Аудитыг хийж гүйцэтгэхдээ дүрэм, стандартын зарим шаардлагыг баримтлаагүй байна.

2.1.2 Дотоод аудитын чиг үүргийн хэрэгжилт хангалтгүй байна.

2.1.3 Төсвийн ерөнхийлөн захирагчаас дотоод аудитын нэгжийн чиг үүргээ хэрэгжүүлэх бодлогын хэмжээний зарим ажлыг орхигдуулсан байна.

2.1.4 Хяналт шалгалтын талаарх мэдээллийг facebook хуудсаар мэдээлсэн байна.

2.1.5 Удирдлага, арга зүйгээр хангах дээд шатны байгууллагатай харилцан уялдаатай ажиллаж байна.

2.2 Дотоод аудитын үйл ажиллагааны чанар, үр нөлөөг сайжруулах шаардлагатай байна.

2.2.1. Эрх бүхий байгууллагаас чанарын хяналтын үнэлгээ хийгдээгүй байна

2.2.2. Дотоод аудитаар илэрсэн алдаа, зөрчилд, өгсөн зөвлөмжийн 2016-2020 оны хэрэгжилтийн дунджаар 89 хувьтай байна.

2.2.3. Нийт зөрчлийн дийлэнх хувийг цалингийн тооцоолол, төсвийн хөрөнгийн үр ашигт байдалтай холбоотой зөрчил эзэлж байна.

|                                     |    |
|-------------------------------------|----|
| Холбогдох байгууллагын санал: ..... | 24 |
| Санал өгсөн тайлбар .....           | 25 |
| Дүгнэлт: .....                      | 26 |
| Зөвлөмж: .....                      | 27 |

**ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ:**

|                |                                                       |
|----------------|-------------------------------------------------------|
| <b>АДБОУС</b>  | Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт         |
| <b>ААНБ</b>    | Аж ахуйн нэгж байгууллага                             |
| <b>ҮАГ</b>     | Үндэсний аудитын газар                                |
| <b>ДАИ</b>     | Дотоод аудитын институт                               |
| <b>ДАОУМПХ</b> | Дотоод аудитын олон улсын мэргэжлийн практикийн хүрээ |
| <b>ДАОУИ</b>   | Дотоод аудитын олон улсын институт                    |
| <b>ЗДТГ</b>    | Засаг даргын Тамгын газар                             |
| <b>ОУМПХ</b>   | Олон улсын мэргэжлийн практикийн холбоо               |

### Хүснэгтийн товъёг

| №         | Тайлбар                                                                                                                            | Хуудасны дугаар |
|-----------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------|
| Хүснэгт 1 | Батлагдсан орон тоонд хяналт, шалгалтын ажлыг гүйцэтгэсэн дундаж хоног                                                             | 8               |
| Хүснэгт 2 | Байгууллагын бүтэц, орон тоо, ажлын байрны захиалгын талаарх мэдээлэл                                                              | 8               |
| Хүснэгт 3 | Санхүүгийн хяналт, аудитын албаны хийж гүйцэтгэсэн хяналт шалгалтын мэдээлэл                                                       | 12              |
| Хүснэгт 4 | Санхүүгийн хяналт, аудитын албаны 2015-2021 оны эхний хагас жилийн байдлаар тогтоосон акт, өгсөн албан шаардлагын талаарх мэдээлэл | 14              |
| Хүснэгт 5 | Санхүүгийн хяналт, аудитын албаны тогтоосон акт, өгсөн албан шаардлагын хэрэгжилт                                                  | 18              |

### График

| №          | Тайлбар                         | Хуудасны дугаар |
|------------|---------------------------------|-----------------|
| График 1   | Батлагдсан төсөв /2015-2021 он/ | 9               |
| График 2   | Дундаж цалин                    | 9               |
| График 3-4 | Акт, албан шаардлага            | 19              |
| График 5   | Санал, асуулгын дүн             | 20              |

|                                                  |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                     |
|--------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| <p><b>Аудит хийх үндэслэл, бүрэн эрх</b></p>     | <p><b>Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл</b></p> <p>Аудитыг Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/27 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, 2021 оны А/28 дугаар тушаалаар батлагдсан аудитын төлөвлөгөөний дагуу, Үндэсний аудитын газрын нэгдсэн удирдамжаар Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд гүйцэтгэв.</p>                                                                                                                                     |
| <p><b>Аудитын зорилт</b></p>                     | <p>Төрийн байгууллагуудын дотоод аудитын тогтолцоо, чиг үүргийн хэрэгжилтэд аудит хийж, дүгнэлт зөвлөмж боловсруулан дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдлээ.</p> <p>Уг зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын дагуу аудитыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Төрийн байгууллагуудын дотоод аудитын тогтолцоо оновчтой эсэх;</li> <li>- Төрийн байгууллагууд дотоод аудитын чиг үүргээ үр дүнтэй хэрэгжүүлж байгаа эсэх.</li> </ul>                                                            |
| <p><b>Аудитын хамарсан хүрээ</b></p>             | <p>Аудитад төрийн байгууллагуудын дотоод аудитын зорилго, зорилт, арга хэмжээг хариуцан хэрэгжүүлэх Сангийн яам, Төсвийн ерөнхийлөн захирагчид болон тэдгээрийн харьяа агентлаг, байгууллагуудын дотоод аудитын үйл ажиллагаанд Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газар аудит хийж гүйцэтгэв.</p>                                                                                                                                                                                                                                                                                 |
| <p><b>Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт</b></p> | <p>Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 300, 3000-3100 үндэслэн боловсруулсан Гүйцэтгэлийн аудитын журамд заасан арга зүйг ашиглан дарга, тэргүүлэх аудиторын баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийг мөрдлөг болгон ажиллаа. Хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горимын дагуу нотлох зүйл цуглуулж, холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга авах, иргэн, ААНБ-ын үйл ажиллагаатай танилцах, судалгаанд тулгуурлан дүн шинжилгээ хийж, аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.</p> |
| <p><b>Аудитын бүрэлдэхүүн, хугацаа</b></p>       | <p>Аудитыг дарга, тэргүүлэх аудитор Т.Ган-Өлзий хянан удирдаж, аудитын менежер У.Оюунтүлхүүр аудитын стандарт, арга зүйн дагуу хяналт тавьж, аудитор Б.Уранбилэг, Л.Равдандорж нар хийж гүйцэтгэв.</p> <p>Аудитыг 2021 оны 09 дүгээр сарын 06-нд эхэлж, 10 дугаар сарын 31-ний өдрийн дотор хийж гүйцэтгэнэ. Аудитын тайланг УАГ болон бусад холбогдох газар, албан тушаалтанд 2021 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн дотор хүргүүлнэ.</p>                                                                                                                                          |

**Хүндрэл бэрхшээл**

Цар тахалтай холбоотойгоор зарим байгууллагын албан тушаалтан, ажиллагсад өвчтэй байсан тул ярилцлага хийх, судалгаа авахад хүндрэлтэй байв.

## **БҮЛЭГ 1. ДОТООД АУДИТЫН НЭГЖИЙН ТОГТОЛЦОО ОНОВЧГҮЙ БАЙНА.**

### **1.1 Дотоод аудитыг хэрэгжүүлэхтэй холбоотой эрх зүйн орчин бүрдсэн байна.**

#### **1.1.1 Дотоод аудитын үйл ажиллагааг зохицуулах эрх зүйн баримт бичгүүд батлагдсан байна.**

Засгийн газрын 2014 оны 327 дугаар тогтоолоор Төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор Мэргэжлийн хяналтын байгууллагын санхүүгийн хяналт шалгалтын чиг үүргийг Сангийн яаманд шилжүүлсэн байна. Үүний дагуу аймгийн Засаг даргын 2014 оны А/577 дугаар захирамжаар “Санхүүгийн хяналт, аудитын алба”-ыг 6 орон тоотой байгуулж, аймгийн МХГ-ын санхүүгийн хяналт, шалгалтын байцаагч нар шилжин ажилласан байна.

Дээрх алба нь Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1-д “Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна” гэсэн үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэхээр хуульчлагдсан байна.

Мөн дотоод аудитын үйл ажиллагааг зохицуулах салбар хууль байхгүй хэдий ч Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор “Дотоод аудитын дүрэм”, Сангийн сайдын 2015 оны 348 дугаар тушаалаар “Байгууллагын эрсдэлийн удирдлагад дотоод аудитыг нэвтрүүлэх заавар”, 2016 оны 274 тушаалаар “Дотоод аудитын чанарын үнэлгээний аргачлал” 107 дугаар тушаалаар “Санхүүгийн хяналт шалгалтын стандарт”, 2019 оны 29 дүгээр тушаалаар “Дотоод аудитын хорооны дүрэм”, 268 дугаар тушаалаар “Улсын салбарын дотоод аудитын аргачлал” зэрэг эрх зүйн бусад баримт бичгүүд батлагдсан байна.

Мөн Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор “Аж ахуй нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-ын 1 дэх хэсгийн 1.4.2-т “Өөрийн болон доод шатны Засаг даргын ажлын алба харьяа байгууллага, аж ахуй нэгжид мөрдөх дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журмыг аймгийн Засаг дарга батална” гэж заасан байна. Үүний дагуу аймгийн Засаг даргын 2015 оны А/04 дугаар захирамжаар “Санхүүгийн хяналт, аудитын албаны үйл ажиллагааны дүрэм”-ийг баталсан байна.

Засгийн газрын 2015 оны 483 дугаар тушаалаар батлагдсан “Дотоод аудитын дүрэм”-ийн 7 дахь хэсгийн 7.1-д “Дотоод аудитын нэгж нь тухайн жилийн болон дунд хугацааны төлөвлөгөөтэй байх бөгөөд төсвийн ерөнхийлөн захирагч батална” гэж заасны дагуу аймгийн Засаг даргын 2019 оны А/632 дугаар захирамжаар “Орон нутагт дотоод аудитыг хөгжүүлэх дунд хугацааны стратеги”-ийг баталсан байна.

Засгийн газрын 2015 оны 483 дугаар тушаалаар батлагдсан “Дотоод аудитын дүрэм”-д дотоод аудитын нэгжийг мэргэжил, арга зүй, зөвлөмжөөр хангах чиг үүргийг Сангийн яаманд хариуцуулсан. Харин бүтцийн хувьд орон нутаг дахь ТЕЗ-ийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарч байгаа нь тогтолцооны оновчгүй зохион байгуулалтыг хийсэн байна.

### **1.1.2 Стандартад заасны дагуу дотоод аудитын нэгжийн дүрмийн зарим шаардлага тусгагдаагүй байна.**

Дотоод аудитыг хийж гүйцэтгэхэд гол баримтлах стандарт нь ДАИ-ээс гаргасан ОУМПХ<sup>1</sup>, холбоотой зааврууд болон дотоод аудитын нийтээр хүлээн зөвшөөрсөн стандарт, зарчмууд байна.

Дотоод аудитын мэргэжлийн практикийн стандартад дотоод аудитын нэгж нь ДАИ-ийн олон улсын мэргэжлийн практикийн хүрээний заавал мөрдөх удирдамж, түүний дотор ДАМП-ын үндсэн зарчмууд, ёс зүйн дүрэм, ДАМПОУС болон дотоод аудитын тодорхойлолтыг баримталж бие даан ажиллаж, дотоод аудитор нь стандартыг баримтлах ёстой. Дотоод аудитын нэгж нь стандартад заасан шаардлагуудыг бүрэн тусгасан дүрэмтэй байх ба энэ нь олон улсын стандартын шаардлага гэж тодорхойлсон.

Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан дотоод аудитын дүрэмд төсөв захирагчдын дотоод аудитын үйл ажиллагааны зорилго, хамрах хүрээ, зарчим, зохион байгуулалт, дотоод аудитор, санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагчийн эрх, үүргийг тодорхойлж, дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын үйл ажиллагааг явуулах, хөндлөнгийн аудитын байгууллагатай хамтран ажиллах зэрэг харилцааг зохицуулахаар батлагдсан байна. Энэ дүрэм нь төсвийн ерөнхийлөн захирагчийн дэргэдэх санхүүгийн хяналт, аудитын албаны үйл ажиллагаанд хамаарахаар хуульчлагдсан<sup>2</sup>.

Харин Санхүүгийн хяналт, аудитын албаны дүрэмд үйл ажиллагааны зорилго, зохион байгуулалт, үндсэн зарчим, чиглэл, санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч, дотоод аудиторын эрх, үүрэг, санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудитыг төлөвлөх, хэрэгжүүлэх, ажлын баримт, хараат бус байдал, хөндлөнгийн аудиттай харилцах, шалгагч байгууллагын үүрэг гэсэн ерөнхий шаардлагуудыг тусган баталсан байна.

ДАОУМПХ-д дотоод аудитын дүрэм нь ДАОУИ-ээс гаргасан үндсэн тунхаглалтай нийцсэн байхаар тодорхойлсон. Үүний дагуу Санхүүгийн хяналт, аудитын албаны үйл ажиллагааны дүрмийг дотоод аудитын загвар дүрэмтэй харьцуулан авч үзэхэд дараах зарим шаардлагуудыг тусгаагүй байна. Үүнд:

- *Дотоод аудитын үйл ажиллагааны хамрах хүрээнд байгууллагын засаглал, эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын зохистой, үр нөлөөт байдлыг хараат бусаар үнэлж, гүйцэтгэх удирдлага бусад талд танилцуулах зорилгоор нотлох зүйлсийг бодитой шалгах ажил хамаарах бөгөөд дүрэмд үйл ажиллагааны хамрах хүрээг тусгасан байх;*
- *Аудитын гүйцэтгэх удирдлагын хүлээх үүргийг тусгах;*
- *Бүхий л чиг үүргийг хамарсан чанарын баталгаажуулалт ба сайжруулалтын хөтөлбөртэй байна. Үүнд дотоод аудитын стандартад нийцэж ажилласан эсэх, ёс зүйн дүрмийг мөрдсөн эсэхийг хэрхэн үнэлэх талаар тусгах зэрэг шаардлагуудыг байна.*

Мөн ДАОУМПХ-д дотоод аудитын дүрмийг тогтмол хугацаанд эргэн нягталж, дотоод аудитын нэгжийн чиг үүрэг, ажлын цар хүрээнд өөрчлөлт оруулах эсэхэд анхаарч ажиллах шаардлагатай гэж заасан.

<sup>1</sup> IPPF-International Professional Practices Framework

<sup>2</sup> Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.5-д “Дотоод аудитын албаны дүрмийг Засгийн газар батална”



Харин Санхүүгийн хяналт, аудитын албаны дүрмийг 2015 онд батлагдсанаас хойш нэмэлт өөрчлөлт ороогүй байна.

Иймд Санхүүгийн хяналт, аудитын үйл ажиллагааны дүрмийг ДАОУМПХ-д заасан шаардлагыг бүрэн тусгаж, шаардлагатай нэмэлт өөрчлөлт хийх тухай зөвлөмжийг хүргүүлэхээр шийдвэрлэв.

## **1.2 Дотоод аудитын нэгж нь чиг үүргээ бүрэн хэрэгжүүлэх боломжтой бүтэц, хөрөнгөөр хангагдсан боловч мэргэжлийн хүний нөөц дутагдалтай байна.**

### **1.2.1. Дотоод аудитын чиг үүргийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд орон нутгаас дэмжсэн байна.**

#### **Байгууллагын бүтцийн талаар:**

Санхүүгийн хяналт, аудитын албыг 2014 онд удирдах албан тушаалтан 1, гүйцэтгэх албан тушаалтан 5, нийт 6 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан байна. Бүтцийг аймгийн Засаг даргын 2015 оны А/332 захирамжаар 8, 2019 оны А/661 дүгээр захирамжаар 10 орон тоотой ажиллахаар шинэчлэгдэн батлагдсан байна.

(Хүснэгт №1)

Батлагдсан орон тоонд 2015-2020 онд томилогдсон улсын байцаагч, дотоод аудаторуудыг гүйцэтгэсэн хяналт, шалгалтын ажилтай нь хариуцуулахад нэг ажилтан дунджаар ажлын 27 өдөрт хяналт шалгалтыг гүйцэтгэсэн байна. (Хүснэгт№1)

| Он     | Орон тоо | Тухайн жилийн гүйцэтгэсэн аудит | Нэг хүнд ногдох |                    |
|--------|----------|---------------------------------|-----------------|--------------------|
|        |          |                                 | Аудитын тоо     | Ажлын дундаж хоног |
| 2015   | 6        | 30                              | 5               | 46                 |
| 2016   | 7        | 87                              | 12              | 19                 |
| 2017   | 7        | 75                              | 11              | 22                 |
| 2018   | 7        | 77                              | 11              | 21                 |
| 2019   | 7        | 57                              | 8               | 28                 |
| 2020   | 8        | 76                              | 10              | 24                 |
| Дундаж |          | 67                              | 9               | 27                 |

#### **Хүний нөөцийн талаар:**

Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2-т “Төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан олон нийтэд мэдээлэх үүрэгтэй. Томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан сул орон тоо гарсан өдрөөс хойш энэ тухай мэдээллийг долоо хоногт, сонгон шалгаруулалт явуулах захиалгыг 21 хоногт багтаан төрийн албаны холбогдох шатны байгууллагад хүргүүлнэ” гэж заасан. Дутуу орон тоонд Төрийн албан салбар зөвлөлд захиалга өгсөн байдлыг авч үзвэл дараах байдалтай байна. (Хүснэгт №2)

#### **Байгууллагын бүтэц, орон тоо, ажлын байрны захиалгын талаарх мэдээлэл**

(Хүснэгт №2)

| № | Үзүүлэлт               | 2014 | 2015 | 2016 | 2017 | 2018 | 2019 | 2020 | 2021 оны 10 сар |
|---|------------------------|------|------|------|------|------|------|------|-----------------|
| 1 | Батлагдсан орон        | 6    | 8    | 8    | 8    | 8    | 10   | 10   | 10              |
| 2 | Гүйцэтгэл              | 6    | 8    | 8    | 8    | 6    | 7    | 7    | 6               |
| 3 | Орон тооны илүү, дутуу | -    | -    | -    | -    | 2    | 3    | 3    | 4               |
| 4 | Ажлын байрны захиалга  | -    | -    | -    | -    | -    | 1    | 1    | 2               |
| 5 | Зөрүү                  | -    | -    | -    | -    | 2    | 2    | 2    | 2               |

Дээрх судалгаанаас харахад 2018-2021 онуудад батлагдсан орон тоонд жил бүр 2-4 ажилтан дутуу ажилласан байна. Гэвч шаардлагатай байгаа ажлын байрны захиалгыг холбогдох газарт бүрэн хүргүүлээгүй байна.

Мэргэжлийн боловсон хүчний хувьд дутагдалтай байснаас шалтгаалж 2019 оноос хойш жил бүр гэрээгээр 2-3 дотоод аудитор авч ажиллуулсан байна. Энэ нь дотоод аудитын дүрмийн<sup>3</sup> 4 дэх хэсгийн 4.4-т “Дотоод аудитор нь санхүү, нягтлан бодох бүртгэл, эдийн засаг, эрх зүйн чиглэлээр магистр болон түүнээс дээш зэрэгтэй, тухайн салбарт мэргэжлээрээ 5-аас доошгүй жил ажилласан, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон түүний зөвшөөрлөөр албан ёсоор зохион байгуулсан сургалтад хамрагдсан байна” гэсэн үндсэн шалгуурыг хангахгүй байна.

Мөн энэ нь Засгийн газрын 2003 оны 233 дугаар тогтоолоор батлагдсан “Төсвийн байгууллагын зарим, ажил үйлчилгээг гэрээгээр гүйцэтгүүлэхэд баримтлах чиглэл”<sup>4</sup>-д гэрээгээр гүйцэтгүүлж болох ажил, үйлчилгээний төрөлд хамаарахгүй байна.

Хүний нөөцийн дутагдалтай байдал нь санхүүгийн хяналт шалгалтын болон дотоод аудитын мэргэжлийн чиг үүргийг гүйцэтгэхэд хүндрэлтэй байдлыг бий болгож, хяналт шалгалт, аудитын үр дүн, чанарт нөлөөлөх эрсдэлтэй юм.


Иймд шалгуур хангасан хүний нөөцийг бүрдүүлэхэд анхаарч ажиллах тухай зөвлөмжийг хүргүүлэхээр шийдвэрлэв.

### **Хөрөнгө, нөөцийн талаар:**

Төрийн албаны тухай хуульд төрийн албан хаагчийн цалин хөлс, нөхөн төлбөр, тусламж, нийгмийн баталгааг хэрхэн хангах талаар заасан.

Дотоод аудитын дүрмийн<sup>5</sup> 8 дахь хэсгийн 8.3-т “Төсвийн ерөнхийлөн захирагч нь дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалт болон уг үйл ажиллагааг баримтжуулалтад зайлшгүй хэрэглэх техник, тоног төхөөрөмж, дотоод аудитор чиг үүргээ хараат бусаар, аливаа нөлөөлөлд автахгүйгээр гүйцэтгэхэд бүх талаар дэмжлэг үзүүлж ажиллана” гэж заасан.

Санхүүгийн хяналт, аудитын албаны батлагдсан төсвийг 2015-2021 оны байдлаар авч үзэхэд дараах байдалтай байна. (График №1)



<sup>3</sup> Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан.

<sup>4</sup> 6.2. Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ:

Санхүү, бүртгэлийн үйлчилгээ, эмнэлгийн тусламж, үйлчилгээ /байгууллагаас/, ном, хэвлэл бэлтгүүлэх, худаг, ус, хоолны газрын үйлчилгээ, цэвэрлэгээ, үйлчилгээ, дулаан, сантехникийн үйлчилгээ, цахилгаан хангамжийн үйлчилгээ, усан, хангамжийн үйлчилгээ, холбооны үйлчилгээ, эрүүл ахуй, ариутгалын үйлчилгээ, барилга засвар, мужааны үйлчилгээ, мод, зүлэг, ногоон байгууламжийн үйлчилгээ, мал маллах, харуул, хамгаалалтын үйлчилгээ, галын аюулгүй байдлын үйлчилгээ, үсчин, гоо сайхны үйлчилгээ, хувцас өлгүүрийн үйлчилгээ, биеийн тамир, урлаг соёлын нийтлэг арга хэмжээ, авто гараашны болон авто зогсоолын үйлчилгээ, бусад.

<sup>5</sup> Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан.

Дээрх үзүүлэлтээс харахад байгууллагын төсөв 2015 оноос 2021 оны хүртэлх хугацаанд 2.3 дахин нэмэгдсэн байна.

Мөн ажилчдын албан тушаалын цалин, холбогдох нэмэгдлийг хууль, тогтоомжид заасан хувь хэмжээгээр бүрэн олгож, тухай бүр шийдвэрлэсэн байна. Дундаж цалин хөлс нь анх байгуулагдсан үеэс жил тутамд дунджаар 10 орчим хувиар тогтмол нэмэгдсэн байна. (График № 2)



Ажилчдын нийгмийн болон бусад баталгааг хангах, тэтгэмж, тусламж, нөхөн олговор олгох асуудлыг байгууллагын дотоод журамд тусган хэрэгжүүлсэн байна. Тухайлбал: Ажилчид болон тэдний гэр бүлд зориулж давхардсан тоогоор нийт 102 хүнд 14.2 сая төгрөгийн тусламж тэтгэмж, дэмжлэгийг төсвийн хүрээнд олгожээ.

Хөдөлмөрийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2-т “Ажил олгогч нь ажилтныг ажлаар, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагад тохирсон нөхцөлөөр хангах, хөдөлмөрийн үр дүнд нь тохирсон цалин хөлс олгох, энэ хууль болон хөдөлмөрийн ба хамтын гэрээ, хэлэлцээр, хөдөлмөрийн дотоод журамд заасан үүргээ биелүүлэх үүрэгтэй” гэж заасан.

Мөн ажлын байрны хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, орчин нөхцөлийг Монгол Улсын MNS 5027:2001 стандартад заагдсанаар нэг хүнд ногдох талбайн хэмжээг  $6\text{м}^2$ , эзлэхүүнийг  $20\text{м}^3$ -ээс багагүй байна гэж заасан.

Санхүүгийн хяналт, аудитын алба нь аймгийн Орон нутгийн өмчийн байранд үйл ажиллагаагаа явуулдаг бөгөөд ажилчдын ажиллах өрөөний хэмжээ  $75\text{м}^2$ , амрах өрөөний хэмжээ  $25\text{м}^2$ , албаны даргын өрөөний хэмжээ  $35\text{м}^2$  байна. Энэ нь нэг хүнд ногдох талбайн хэмжээгээрээ холбогдох норм, стандарттай нийцэж байна.

Байгууллагын хөрөнгийн бүртгэлээр нийт 87.4 сая төгрөгийн үндсэн хөрөнгө байна. Одоогоор үйл ажиллагаагаа явуулахад зайлшгүй шаардлагатай, дутагдалтай хөрөнгө байхгүй байна. Мөн аймгийн Засаг даргаас 2015-2021 оны хооронд 53.8 сая төгрөгийн хөрөнгө /автомашин, компьютер, тоног төхөөрөмж/-ийг шийдвэрлэсэн байна.

### **1.2.2. Хөндлөнгийн нөлөөлөлгүй, хараат бусаар ажиллах нөхцөл бүрэн бүрдээгүй байна.**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлд Засаг даргын ажлын алба нь ЗДТГ байна гэж заасан.

Санхүүгийн хяналт, аудитын албыг аймгийн ЗДТГ-ын бүтцэд хамаарахаар батлагдсан байгаа боловч бие даан үйл ажиллагаагаа явуулах төсөв, хөрөнгөтэй түүнийг захиран зарцуулах эрхтэй, бие даасан байдлаар үйл ажиллагаагаа явуулахаар зохион байгуулсан байна.

ДАМПОУС 1110-д “Дотоод аудитын нэгжид үүрэг хариуцлагаа хэрэгжүүлэх боломж олгож буй байгууллагын доторх тухайн түвшинд аудитын гүйцэтгэх удирдлага тайлагнах ёстой. Аудитыг гүйцэтгэх удирдлага дотоод аудитын нэгжийн зохион байгуулалтын хараат бус байдлыг зөвлөлд наад зах нь жил тутам нотолж байх ёстой” гэжээ.

Сангийн сайдын 2016 оны 107 дугаар тушаалаар батлагдсан “Санхүүгийн хяналт шалгалтын стандарт”-ын 5.1-д “Хараат бус байдлыг хангахын тулд санхүүгийн

хяналт шалгалт явуулж байгаа газрын зохион байгуулалт, эрх зүйн байдал хяналт шалгалт явуулах нөхцөлийг бүрдүүлсэн байна”, 5.1.2-т “Хяналт шалгалтын байгууллагын дарга нь байцаагчийн бие даан хараат бус ажиллах тал дээр дэмжлэг үзүүлэх хариуцлагыг хүлээнэ”, 5.1.3-т “Хяналт шалгалтын байгууллагын үүрэг, зорилго, хариуцлагыг албан ёсоор баталж хуульчилсан байна” гэж тус тус заасан.

Санхүүгийн хяналт, аудитын алба нь гүйцэтгэсэн санхүүгийн хяналт, шалгалтын дүн, мэдээг аймгийн Засаг даргад тайлагнаж, шаардлагатай тохиолдолд Засаг даргын дэргэдэх зөвлөлд тухай бүр танилцуулан, хэлэлцүүлсэн байна.

Хэдийгээр Санхүүгийн хяналт, аудитын алба нь тусдаа үйл ажиллагаатай бие даасан байгууллага мэт боловч төсөв санхүүгийн хувьд орон нутгаас санхүүждэг, албаны даргыг ТЕЗ томилж, шууд удирдлагаар хангадаг зэрэг нь хөндлөнгийн нөлөөлөлгүй, хараат бусаар ажиллах боломжийг бүрэн бүрдүүлж чадаагүй байна.

Мөн дотоод аудитын нэгжийн хараат бусаар, хөндлөнгийн нөлөөлөлгүй ажиллах, үйл ажиллагааг зохицуулах эрх зүйн баримт бичиг батлагдаагүй байна.

### **1.2.3. Хүний нөөцийн хүрэлцээгүй байгаагаас зарим ажилчид дотоод аудитын дүрэмд заасан шалгуурыг хангаагүй.**

Дотоод аудитын дүрмийн<sup>6</sup> 4 дэх хэсгийн 4.4-т “Дотоод аудитор нь санхүү, нягтлан бодох бүртгэл, эдийн засаг, эрх зүйн чиглэлээр магистр болон түүнээс дээш зэрэгтэй, тухайн салбарт мэргэжлээрээ 5-аас доошгүй жил ажилласан туршлагатай байна” гэж заасан.

Санхүүгийн хяналт, аудитын алба нь 2021 оны байдлаар 9 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байна. Үүнээс үндсэн орон тооны 4 улсын байцаагч, дотоод аудитор, 2 гэрээт аудитор, үйлчилгээний 2 ажилтан, хүүхэд асрах чөлөөтэй 1 улсын байцаагч, дотоод аудитор байна. Үндсэн орон тооны 4 улсын байцаагч, дотоод аудитор нь дүрэмд заасан шаардлагыг хангаж байна. Харин 1 ажилтны мэргэжил, боловсролын зэрэг, ажилласан жил нь дээрх шаардлагын хангахгүй байна.

Дотоод аудитын дүрмийн 4 дэх хэсгийн 4.4-т “Дотоод аудитор нь санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон түүний зөвшөөрлөөр албан ёсоор зохион байгуулсан сургалтад хамрагдсан байна” гэж заасан.

Сангийн яамнаас зохион байгуулсан дотоод аудиторовын сургалтад Санхүүгийн хяналт, аудитын албанаас дотоод аудиторуудыг хамруулсан гэх боловч гэрчилгээг тухай бүр олгоогүй учраас сургалтад хамрагдсан эсэхийг нотлох боломжгүй байна.

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 3 дугаар тогтоолоор батлагдсан “Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам”-ын 3 дахь хэсгийн 3.6-д “Төрийн жинхэнэ албан тушаалд тавигдах шаардлагыг бусад хууль, тогтоомжоор тусгайлан тогтоосон бол тухайн хууль, тогтоомжийн заалтад нийцүүлэн боловсруулна” гэж заасан.

Гэтэл Санхүүгийн хяналт, аудитын албаны даргын 2019 оны А/30 дугаар тушаалаар батлагдсан “Санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч, дотоод аудиторовын албан тушаалын тодорхойлолт нь дотоод аудиторовын дүрэмд заасан зарим шалгуур үзүүлэлтийг бууруулан, зөрүүтэй баталсан байна. Үүнд:

---

<sup>6</sup> Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоол

- “Дотоод аудитор нь санхүү, нягтлан бодох бүртгэл, эдийн засаг, эрх зүйн чиглэлээр магистр болон түүнээс дээш зэрэгтэй” гэснийг “Бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй” байх гэж өөрчилж;
- “Тухайн салбартаа 5-с доошгүй жил ажилласан байх” гэснийг “2-оос доошгүй жил ажилласан байх” гэж хугацааг бууруулсан байна.

Энэ нь Дотоод аудиторын дүрэмд заасан шалгуурыг хангахгүй, мэргэжлийн бус ажилтан авч ажиллуулах нөхцөлийг бүрдүүлж байна.

Мөн журмын 5.1-д “Албан тушаалын тодорхойлолтыг томилох эрх бүхий этгээд шийдвэр гаргаж, албан тушаал тус бүрээр батална” гэж заасан байхад Санхүүгийн хяналт, аудитын албаны санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагч, дотоод аудиторын ажлын байрны тодорхойлолтыг одоог хүртэл батлаагүй байна.

Энэ нь албан хаагчдын гүйцэтгэх ажлын чиг үүргийг тодорхой бус болгож, ажил үүргийн давхардал үүсэх, зарим ажилчдад ажлын ачаалал бий болгох эсхүл ажлын тэнцвэргүй хуваарилалт хийх зэрэг эрсдэлтэй байна.

Иймд ажилчдын албан тушаалын тодорхойлолтыг дүрэмд заасан шаардлагыг бүрэн тусгаж, батлуулан ажиллах тухай зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.

## БҮЛЭГ 2: ДОТООД АУДИТЫН НЭГЖ ХОЛБОГДОХ ХУУЛЬ ТОГТООМЖИД ЗААСАН ЧИГ ҮҮРГИЙГ БҮРЭН ХЭРЭГЖҮҮЛЭЭГҮЙ БАЙНА.

### 21 Санхүүгийн хяналт шалгалтад илүү анхаарч дотоод аудитын чиг үүргийг орхигдуулсан байна.

#### 2.1.1 Аудитыг хийж гүйцэтгэхдээ дүрэм, стандартын зарим шаардлагыг баримтлаагүй байна.

Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1<sup>7</sup>-д заасан чиг үүрэг бүхий албыг ажиллуулна. Мөн хуулийн 69.3-т “Дотоод аудитад төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан хуулийн этгээдийн санхүүгийн үйл ажиллагаа хамаарна” гэж заасан.

Санхүүгийн хяналт, аудитын алба нь 2015-2021 оны эхний хагас жилийн байдлаар нийт 440 байгууллагад (давхардсан тоогоор) хяналт шалгалтыг хийж гүйцэтгэсэн байна. (Хүснэгт №3)

#### Санхүүгийн хяналт, аудитын албаны хийж гүйцэтгэсэн хяналт шалгалтын мэдээлэл

(Хүснэгт №3)

| Хамрах хугацаа | Төлөвлөгөөт шалгалтын тоо | Төлөвлөгөөт бус хяналт шалгалт |                      | Нийт |
|----------------|---------------------------|--------------------------------|----------------------|------|
|                |                           | Тоо                            | Нийт дүнд эзлэх хувь |      |
| 2015           | 30                        |                                |                      | 30   |
| 2016           | 69                        | 18                             | 21%                  | 87   |
| 2017           | 63                        | 12                             | 16%                  | 75   |
| 2018           | 62                        | 15                             | 19%                  | 77   |
| 2019           | 50                        | 7                              | 12%                  | 57   |
| 2020           | 66                        | 10                             | 13%                  | 76   |

<sup>7</sup> Хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна.

|                                            |            |           |            |            |
|--------------------------------------------|------------|-----------|------------|------------|
| 2021 оны эхний<br>хагас жилийн<br>байдлаар | 38         |           |            | 38         |
| <b>Дүн</b>                                 | <b>378</b> | <b>62</b> | <b>15%</b> | <b>440</b> |

Дээрх мэдээллээс харахад жилд дунджаар 50-80 байгууллагын үйл ажиллагаанд шалгалт гүйцэтгэснээс 20 хүртэлх хувийг төлөвлөгөөт бусаар хийсэн байна.

Санхүүгийн хяналт, аудитын алба нь орон нутагт санхүүгийн хяналт шалгалт болон дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлэн ажилладаг ба үйл ажиллагааны үндсэн баримт бичиг болох санхүүгийн хяналт шалгалтын стандарт, дотоод аудитын дүрмийг баримтлан ажиллаж байна.

Стандартаар<sup>8</sup> хяналт шалгалтад хамаарах төрийн захиргааны болон Засгийн газраас байгуулдаг бусад байгууллага, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн санхүүгийн үйл ажиллагааг тодорхой зааж, хяналт шалгалт хийх 9 чиглэлийг тодорхойлсон байна.

Санхүүгийн хяналт аудитын алба нь санхүүгийн хяналт шалгалтад төсвийн ерөнхийлөн захирагчийн хамрах хүрээний болон төрийн болон орон нутгийн өмчит байгууллагыг хамруулсан байна. Харин чиглэлийн хувьд санхүү, төсвийн холбогдолтой хууль тогтоомжийн хэрэгжилт, төсвийн орлогын төлөвлөлт, төвлөрүүлэлт, төсөв, өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт, зарцуулалт, үр ашигт байдал, байгууллагын нягтлан бодогчийн хууль тогтоомжоор заасан үүргийн хэрэгжилт зэргийг хамруулан хяналт шалгалтын ажлыг зохион байгуулсан байна. Эдгээр нь стандартад заагдсан чиглэлүүд хамаарсан байна.

Сангийн сайдын 2019 оны 268 дугаар тушаалаар батлагдсан “Улсын салбарын дотоод аудитын аргачлал”-д дотоод аудитыг хэрхэн гүйцэтгэх үе шатыг нарийвчлан тусгаснаас гадна нийцэл, гүйцэтгэл, санхүүгийн аудитыг гүйцэтгэх арга зүй, аудитад ашиглах загвар ажлын баримтыг багтаасан байна.

Аргачлалын 3 дугаар бүлэгт дотоод аудитын ажлын үе шатыг урьдчилан үнэлэх, аудитыг төлөвлөх, гүйцэтгэх, үр дүнг тайлагнах, зөвлөмжийн хэрэгжилтийг хянах гэсэн үндсэн 5 үе шатыг тодорхойлсон. Үүнээс төлөвлөхөөс өмнө урьдчилан үнэлэх үе шатанд аудитын хэрэгцээ шаардлагыг тодорхойлж, эрсдэлийг урьдчилан үнэлж аргачлал тус бүрийг тусгасан.

Аудитыг төлөвлөх шатанд аудитын ажлын зорилгыг тодорхойлохоос эхлэн сорил хийх эрсдэл хяналтыг төлөвлөх алхам бүрийг заан, загвар ажлын баримтаар баримтжуулахаар тусгасан байна. Мөн 6 дугаар бүлэгт санхүүгийн аудитын хийж гүйцэтгэх арга зүйн талаар тусгагдсан ба аудитыг төлөвлөх, шалгах, тайлагнах гэсэн 3 үе шаттай хэрэгжүүлэхээр тодорхойлсон. Үүнээс төлөвлөх шатанд байгууллагыг судалж, урьдчилсан шинжилгээний горим хэрэгжүүлэх, санхүүгийн тайлангийн материаллаг байдал, гүйцэтгэлийн материаллаг түвшнийг тооцох зэрэг гүйцэтгэх ажлыг тодорхой заасан.

Харин Санхүүгийн хяналт, аудитын албаны 2015-2021 оны эхний хагас жил хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэсэн хяналт шалгалтын ажлын баримтыг үзэхэд дээрх

<sup>8</sup> Сангийн сайдын 2016 оны 107 дугаар тушаалаар “Санхүүгийн хяналт шалгалтын стандарт”-ыг баталсан.



аргачлалд заасан төлөвлөхийн өмнөх болон төлөвлөлтийн шатны баримт байхгүй байна. Үүнд

- *Дотоод аудитын хэрэгцээ шаардлагын ойлгох;*
- *Мэдээллийг хэрхэн олж авч, шинжлэх;*
- *Шалгалтын цар хүрээг хэрхэн тодорхойлох;*
- *Байгууллагын засаглалын удирдлагыг үнэлэх;*
- *Байгууллагын дотоод хяналтыг үнэлэх;*
- *Эрсдэлийг тооцож, үнэлсэн байх зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэсэн эсэх нь тодорхойгүй, баримтжуулалт байхгүй байна.*

Мөн түүнчлэн тухайн жилийн батлагдсан төлөвлөгөөг авч үзэхэд 2015-2021 онд нийт 378 байгууллагад хяналт шалгалт хийхээр төлөвлөн гүйцэтгэсэн байна. Үүнээс Сайншанд сумын 1, 6, 11-р цэцэрлэг, Замын-Үүд сумын “Чандмань бадрал” ОНӨХХК-д 4-5 удаа төлөвлөгөөт шалгалтыг хийсэн байна. Тухайн жилийн шалгалтад хамрагдах байгууллагыг ямар эрсдэлд үндэслэн, жил бүрийн төлөвлөгөөнд тусгаж байгаа нь тодорхойгүй байна.

Аудитын төлөвлөлт нь тухайн хяналт шалгалтын чухал хэсэг байдаг ба төлөвлөлтийг хангалтгүй хийж гүйцэтгэснээр аудит чанаргүй, үр дүнгүй болж, цаг хугацаа алдах эрсдэлийг дагуулдаг. Мөн аудитын ажлын баримтыг тухай бүр үйлдэн баримтжуулж ажиллах нь стандартын гол шаардлага байдаг.

Иймд аудитыг төлөвлөхийн өмнөх болон төлөвлөлтийн шатны ажлыг холбогдох стандартад тусгасны дагуу хийж гүйцэтгэж, аудитын ажлыг тухай бүр бүрэн баримтжуулж ажиллах тухай зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.

### ***2.1.2 Дотоод аудитын чиг үүргийн хэрэгжилт хангалтгүй байна.***

Төсвийн тухай хуулиар<sup>9</sup> Санхүүгийн хяналт аудитын алба нь хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийж үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргахаас гадна эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитыг хэрэгжүүлэх чиг үүрэгтэйгээр байгуулагдсан.

ДАОУИ-ээс гаргасан ОУМПХ-д дотоод аудитыг байгууллагын үнэ цэнийг нэмэгдүүлэх, үйл ажиллагааг сайжруулахад чиглэсэн хараат бус, бие даасан, бодитойгоор баталгаажуулах, зөвлөх үйл ажиллагаа ба системтэй, оновчтой арга хандлагаар байгууллагын засаглал, эрсдэлийн удирдлага болон дотоод хяналтын үйл явцуудын үр нөлөөтэй байдлыг үнэлж сайжруулахад туслах үүрэгтэй гэж тодорхойлсон.

Судалгаагаар тус алба 2015-2021 оны эхний хагас жил хүртэлх хугацаанд нийт 425 байгууллагад (давхардсан тоогоор) санхүүгийн хяналт шалгалт, 15 байгууллагад дотоод аудитыг хийж гүйцэтгэсэн байна.

Нийт шалгалтын дийлэнх хувийг санхүүгийн хяналт шалгалт эзэлж байна. Санхүүгийн хяналт, шалгалтыг хийснээр санхүүгийн сахилга бат, хариуцлага сайжрах ч хуулиар тогтоосон эрсдэлийн удирдлагаар хангах чиг үүрэг орхигдох, дотоод аудитыг хэрэгжүүлэх дунд хугацааны стратеги төлөвлөгөө (бодлогын баримт бичиг)-ний хэрэгжилт хангагдахгүй байх зэрэг үр дагаврыг үүсгэж байна.

---

<sup>9</sup> Хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1-д заасан.

Мөн Санхүүгийн хяналт, аудитын алба нь 2015 оноос 2021 оны эхний хагас жилийн байдлаар нийт 1516 байгууллага, албан тушаалтанд (давхардсан тоогоор) 2,888.9 сая төгрөгийн акт, албан шаардлагыг тогтоосон байна. (Хүснэгт №4)

**Санхүүгийн хяналт, аудитын албаны 2015-2021 оны эхний хагас жилийн байдлаар тогтоосон акт, өгсөн албан шаардлагын талаарх мэдээлэл**

(Хүснэгт №4)

| Хамрах хугацаа           | Акт         |                  | Албан шаардлага |                  | Нийт        |                  |
|--------------------------|-------------|------------------|-----------------|------------------|-------------|------------------|
|                          | Тоо         | Дүн /сая төгрөг/ | Тоо             | Дүн /сая төгрөг/ | Тоо         | Дүн /сая төгрөг/ |
| 2015                     | 0           |                  | 0               | 0                | 0           | -                |
| 2016                     | 293         | 277.9            | 13              | 51.8             | 306         | 329.7            |
| 2017                     | 237         | 226.6            | 24              | 341.5            | 261         | 568.1            |
| 2018                     | 306         | 204.9            | 8               | 772.6            | 314         | 977.5            |
| 2019                     | 188         | 303.5            | 1               | 5.9              | 189         | 309.4            |
| 2020                     | 304         | 300.2            | 4               | 81.0             | 308         | 381.2            |
| 2021 оны эхний хагас жил | 125         | 223.5            | 13              | 99.6             | 138         | 323.0            |
| <b>Дүн</b>               | <b>1453</b> | <b>1,536.6</b>   | <b>63</b>       | <b>1,352.3</b>   | <b>1516</b> | <b>2,888.9</b>   |

Дээрх мэдээллээс харахад нийт алдаа, зөрчлийн 53 хувьд нь акт тогтоож, 47 хувьд нь албан шаардлага өгчээ.

Тогтоосон акт, албан шаардлагын үндэслэлийг авч үзэхэд Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Дотоод аудитын дүрмийг ерөнхий байдлаар тусгасан байна. Харин акт тогтоох, албан шаардлага өгөх эрх дурдагдаагүй байна.

Дотоод аудитын дүрмийн<sup>10</sup> 6 дахь хэсгийн 6.3.1-д дотоод аудитор нь “Санхүүгийн хяналт шалгалтын тэмдэглэл болон нэг бүрчилсэн акт, танилцуулга, аудитын зөвлөмжийг хууль тогтоомж болон баримт нотолгоонд үндэслэн гаргах үүрэгтэй”, Санхүүгийн хяналт шалгалтын стандартад<sup>11</sup> акт, албан шаардлагыг бичих ерөнхий зааврыг заасан.

Харин санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч, дотоод аудитор нь шалгагдагч этгээдийг алдаа зөрчил гаргасан гэж үзвэл цуглуулсан нотлох зүйлд тулгуурласан ямар нөхцөл байдалд акт тогтоож, ямар нөхцөлд албан шаардлага өгөх нь тодорхойгүй, зохицуулсан эрх зүйн баримт бичиг байхгүй байна.

Иймд акт тогтоох, албан шаардлага өгөх харилцааг зохицуулах эрх зүйн баримт бичиг боловсруулах шаардлагатай байгаа тухай саналыг УАГ-т уламжлан хүргүүлэхээр шийдвэрлэв.

**2.1.3 Төсвийн ерөнхийлөн захирагчаас дотоод аудитын нэгжийн чиг үүргээ хэрэгжүүлэх бодлогын хэмжээний зарим ажлыг орхигдуулсан байна.**

Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан “Дотоод аудитын дүрэм”-д дотоод аудитын үйл ажиллагаа нь ил тод, бие даасан, хараат бус байж, хяналт шалгалт, аудитын дүнг бодитой, үнэн зөв, шударгаар тайлагнах, багаар ажиллах зарчим баримтална”, 7 дахь хэсгийн 7.1-д “Дотоод аудитын нэгж нь тухай

<sup>10</sup> Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан дүрэм.

<sup>11</sup> Сангийн сайдын 2016 оны 107 дугаар тушаалаар батлагдсан стандарт.



жилийн болон дунд хугацааны төлөвлөгөөтэй байх бөгөөд төлөвлөгөөг төсвийн ерөнхийлөн захирагч батална” гэж заасан.

Мөн ДАМПОУС-д дотоод аудитын төлөвлөхөд хоорондоо ялгаатай зорилго бүхий хоёр төрлийн төлөвлөгөөг ашигладаг ба энэ нь аудитын дунд хугацааны төлөвлөгөө болон жилийн төлөвлөгөөг ашиглахаар тусгасан.

Аймгийн Засаг даргын захирамжаар “Орон нутагт дотоод аудитыг хөгжүүлэх дунд хугацааны стратеги”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хамт баталсан. Стратегийг 2019-2021 онуудад шатлан хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Мөн жил бүр тухайн жилийн санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудитын төлөвлөгөөг боловсруулан баталж, аймгийн ТЕЗ-тай үр дүнгийн гэрээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган батлуулсан байна.

Харин төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг Сангийн яамнаас ирүүлсэн нэгдсэн удирдамжаар, иргэний болон төрийн албан хаагчдаас ирүүлсэн хүсэлт, өргөдөл, гомдлоор, аймгийн ТЕЗ-ийн ирүүлсэн албан бичгийн дагуу хийж гүйцэтгэсэн байна.

Хэдийгээр олон хяналт шалгалт хийх нь тухайн жилийн ажлын үзүүлэлтийг нэмэх боловч ажлыг гүйцэтгэж байгаа алба хаагчдын ажлын ачааллыг нэмэгдүүлэх, тухайн жилийн төлөвлөгөөт ажлыг бүрэн хэрэгжүүлэх боломжгүй байдалд хүргэх, шалгалтыг чанаргүй хийж гүйцэтгэх зэрэг үр дагавартай.

Харин аудитын удирдамж батлах, гүйцэтгэх, шалгалтын тэмдэглэл бичих, илэрсэн алдаа зөрчилд акт тогтоох, албан шаардлага, зөвлөмжийг хүргүүлж, хэрэгжилтийг тооцсон байна.

Дотоод аудитын дүрмийн<sup>12</sup> 4 дэх хэсгийн 4.12-т “Төсвийн ерөнхийлөн захирагч нь дэргэдээ Дотоод аудитын хороотой байж болох бөгөөд хороог тухайн төсвийн ерөнхийлөн захирагч даргална”, 4.13-т “Дотоод аудитын хорооны бүрэлдэхүүнийг ерөнхийлөн захирагч батална”, 7 дахь хэсгийн 7.7-д “хяналт шалгалт, аудитын тайланг Дотоод аудитын хороотой бол хэлэлцүүлнэ” гэж тус тус заасан.

Аймгийн Засаг даргын Сангийн сайдтай 2021 онд хамтран ажиллах гэрээний 3 дахь хэсгийн 3.28-д “Сангийн сайдын 2013 оны 29 дүгээр тушаалаар батлагдсан “Дотоод аудитын хорооны дүрэм”-ийн дагуу үйл ажиллагаа явуулж, хорооны хурлаар шийдвэрлэсэн асуудал, хэрэгжилтийн тайланг хагас, бүтэн жилээр Сангийн яаманд хүргүүлнэ” гэж тусгасан байна.

Мөн орон нутагт дотоод аудитыг хөгжүүлэх дунд хугацааны стратегийг хэрэгжүүлэх арга хэмжээний<sup>13</sup> 7 дахь хэсгийн 7.1-д “Төсвийн ерөнхийлөн захирагчийн дэргэдэх Дотоод аудитын нэгж нь стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллах үүрэгтэй бөгөөд хэрэгжилтийн явц, үр дүнг Дотоод аудитын хороонд жил бүр тайлагнаж ажиллана” гэж тусгасан.

Гэтэл аймгийн ТЕЗ-аас Дотоод аудитын дүрмийн дээрх заалт нь аудитын хороог заавал байгуулна гэсэн шинжийг агуулаагүй бөгөөд шаардлагатай эсэхийг судалж байгаа тул одоогоор тус хороог байгуулаагүй гэсэн албан бичгийг ирүүлсэн байна.

Үүнээс дүгнэхэд дотоод аудитыг хэрэгжүүлэх богино болон дунд хугацааны бодлогын баримт бичиг, дээд шатны байгууллагатай байгуулсан гэрээ нь ирүүлсэн албан бичигтэй уялдаагүй, хоорондоо зөрчилтэй байна.

<sup>12</sup> Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан.

<sup>13</sup> Аймгийн Засаг даргын 2019 оны А/632 дугаар захирамжаар батлагдсан.

Иймд дотоод аудитын нэгжийн богино болон дунд хугацааны бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэхэд анхаарч ажиллах зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.

#### **2.1.4 Хяналт шалгалтын талаарх мэдээллийг facebook хуудсаар мэдээлсэн байна.**

Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлд улс орон нутгаас санхүүждэг байгууллагууд үйл ажиллагааныхаа ил тод байдлыг хангах чиглэлээр арга хэмжээ авч ажиллана гэж заасан.

Аймгийн Санхүүгийн хяналт, аудитын алба нь байгууллагын мэдээллийн ил тод байдлыг хангах, иргэд олон нийтэд мэдээллийг “Дорноговь аймгийн Санхүүгийн хяналт, аудитын алба” нэртэй FACEBOOK хуудсаар дамжуулан хүргэсэн байна. Мэдээлсэн байдлыг үзэхэд жилийн төлөвлөгөө, цаг үеийн шинжтэй мэдээлэл, төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалт, илэрсэн зөрчил, авсан арга хэмжээний талаарх товч мэдээлэл, сэрэмжлүүлэг, байгууллагын үйл ажиллагааны мэдээлэл, ололт амжилт зэрэг мэдээллийг байршуулсан байна.

Харин орон нутгийн үндсэн цахим хуудас (dornogovi.gov.mn) байгууллагын үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл байхгүй байна.

#### **2.1.5 Удирдлага, арга зүйгээр хангах дээд шатны байгууллагатай харилцан уялдаатай ажиллаж байна.**

Дотоод аудитын дүрмийн 4 дэх хэсгийн 4.8-д “Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь дотоод аудитын нэгжийг мэргэжил, арга зүйн зөвлөмжөөр хангаж ажиллана” гэж заасан.

Сангийн сайдын аймгийн Засаг даргын байгуулсан хамтран ажиллах гэрээний<sup>14</sup> 2 дахь хэсэгт Сангийн сайд нь эрсдэлд суурилсан дотоод аудитын төлөвлөгөөний дагуу орон нутгийн төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтыг зохион байгуулж, зөвлөмжөөр хангана гэж тусгажээ.

Харин аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны даргын Засаг даргатай байгуулсан хамтран ажиллах гэрээнд Засаг дарга нь “..., төсвийн хөрөнгийн зарцуулалтад хийх хяналт шалгалтын үр өгөөжийг дээшлүүлэх зорилт арга хэмжээг хэрэгжүүлж байгаа байдалд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, хэрэгжилтийг хангах ажлыг нэгдсэн удирдлагаар хангах” гэж тусгасан байна. Мөн албаны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалт хийх ажлуудыг тусгаж, тайлант онд хэрэгжүүлэх “Санхүүгийн хяналт, шалгалт, дотоод аудитын нэгдсэн удирдамж”-ыг баталсан байна.

Дүрмийн 7 дахь хэсгийн 7.9-д төсвийн ерөнхийлөн захирагчийн дэргэдэх санхүүгийн хяналт шалгалт, аудитын нэгж нь хагас, бүтэн жилийн тайлангаа санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад жил бүрийн 7 дугаар сарын 10-ны өдөр болон тухайн жилийн 1 дүгээр сарын 10-ны өдрийн дотор хүргүүлнэ гэж заасан. Үүний дагуу аймгийн Санхүүгийн хяналт, аудитын алба нь холбогдох тайланг тухай бүр хүргүүлсэн байна.

Дүрмийн<sup>15</sup> 9 дэх хэсэгт дотоод аудитын нэгж нь төрийн аудитын байгууллагатай жилийн ажлын төлөвлөгөө, тайланг харилцан мэдээлэх, хамтарсан

<sup>14</sup> Сангийн сайдын аймгийн Засаг даргатай 2021 онд хамтран ажиллах гэрээ.

<sup>15</sup> Засгийн газрын 2015 оны 483 дугаар тушаалаар батлагдсан дүрэм.

сургалт зохион байгуулах, арга зүй, туршлага, мэдээлэл харилцан судлах, солилцож хамтран ажиллаж болно гэж заасан байна.

Харин Төрийн аудитын байгууллагатай хамтран зохион байгуулсан ажил байхгүй байна.

## 22 Дотоод аудитын үйл ажиллагааны чанар, үр нөлөөг сайжруулах шаардлагатай байна.

### 2.2.1. Эрх бүхий байгууллагаас чанарын хяналтын үнэлгээ хийгдээгүй байна.

Дотоод аудитын дүрмийн<sup>16</sup> 8 дахь хэсгийн 8.5-д “Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь төсвийн ерөнхийлөн захирагчийн болон бусад төсвийн захирагчдын дотоод аудитын үйл ажиллагаанд дотоод аудитын мэргэжлийн практикийн олон улсын стандартын дагуу чанарын хяналтын үнэлгээг 2 жилд 1 удаа хийнэ” гэж заасан.

Аудитын хамрах хугацаанд Сангийн яамнаас чанарын хяналтын үнэлгээг огт хийгээгүй, үнэлэлт, дүгнэлт өгөөгүй байна. Харин аудитын явцад 2020-2021 оны эхний хагас жилийн үйл ажиллагаанд чанарын үнэлгээ хийгдэж байгаа гэх боловч албан бичиг, удирдамж ирүүлээгүй байна.

### 2.2.2. Дотоод аудитаар илэрсэн алдаа, зөрчилд, өгсөн зөвлөмжийн 2016-2020 оны хэрэгжилтийн дунджаар 89 хувьтай байна.

Дотоод аудитын дүрмийн 6 дахь хэсгийн 6.3.5-д “Дотоод аудитор буюу санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч нь шалгалтын дүнд тулгуурлан гаргасан шийдвэрийн биелэлтэд хяналт тавьж, зохих журмын дагуу биелэлтийг хангуулах арга хэмжээ авна”, 6 дахь хэсгийн 8.2-т “Дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагнал, нэг бүрчилсэн акт, албан шаардлага, аудитын зөвлөмжийн мөрөөр авах арга хэмжээний үе шат бүрийн явцын талаар зохих стандартын дагуу архивын нэгж үүсгэн архивд хүлээлгэн өгнө” тус тус заасан байна.

Аудитаар илэрсэн алдаа, зөрчилд өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын биелэлтийг аудитор бүр өөрсдөө хариуцах бөгөөд санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагч, дотоод аудитор хэрэгжилтийг нэгтгэж, хяналт тавьж ажиллаж байна.

Санхүүгийн хяналт, аудитын алба нь 2015-2021 онд нийт 440 хяналт, шалгалтыг хийсэн байна. (Хүснэгт №5)

#### Санхүүгийн хяналт, аудитын албаны тогтоосон акт, өгсөн албан шаардлагын хэрэгжилт

(Хүснэгт №5)

| № | Хамрах хугацаа | Хяналт шалгалтад хамрагдсан байгууллагын тоо | Нийт зөрчлийн дүн | Төлбөрийн акт |       | Хэрэгжилтийн хувь | Албан шаардлага |       | Хэрэгжилтийн хувь |
|---|----------------|----------------------------------------------|-------------------|---------------|-------|-------------------|-----------------|-------|-------------------|
|   |                |                                              |                   | Тоо           | Дүн   |                   | Тоо             | Дүн   |                   |
| 1 | 2015           | 30                                           |                   |               |       |                   |                 |       |                   |
| 2 | 2016           | 87                                           | 329.7             | 293           | 277.9 | 96%               | 13              | 51.8  | 100%              |
| 3 | 2017           | 75                                           | 568.1             | 237           | 226.6 | 62%               | 24              | 341.5 | 100%              |

<sup>16</sup> Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан

|            |                                |            |                |             |                |     |           |                |      |
|------------|--------------------------------|------------|----------------|-------------|----------------|-----|-----------|----------------|------|
| 4          | 2018                           | 77         | 977.5          | 306         | 204.9          | 97% | 8         | 772.6          | 100% |
| 5          | 2019                           | 57         | 309.4          | 188         | 303.5          | 54% | 1         | 5.9            | 100% |
| 6          | 2020                           | 76         | 381.2          | 304         | 300.2          | 82% | 4         | 81.0           | 100% |
| 7          | 2021 оны<br>эхний хагас<br>жил | 38         | 323.0          | 125         | 223.5          | 25% | 13        | 99.6           | 37%  |
| <b>Дүн</b> |                                | <b>440</b> | <b>2,888.9</b> | <b>1453</b> | <b>1,536.6</b> |     | <b>63</b> | <b>1,352.3</b> |      |

Дээрх мэдээллээс харахад шалгалтаар нийт 2,888.9 сая төгрөгийн алдаа зөрчлийг илрүүлэн, холбогдох албан тушаалтанд хариуцуулсан 1516 акт, албан шаардлагыг хүргүүлж, дунджаар 89 хувийн биелэлттэй байна.

Мөн дотоод аудитын нэгжийн тогтоогдсон акт, өгсөн албан шаардлага, зөвлөмжийг хэрхэн нэгтгэж тайлагнах, хэрэгжилтийг хэрхэн хангаж ажиллах талаар тодорхой журам байхгүй.

Дотоод аудитын дүрмийн 6 дахь хэсгийн 6.3.6-т “Санхүүгийн хяналт шалгалтаар тогтоосон акт, албан шаардлага, зөвлөмжийг хангалтгүй биелүүлсэн албан тушаалтанд хариуцлага тооцох саналыг эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ” гэж заасан.


Харин Санхүүгийн хяналт, аудитын албанаас тогтоосон акт, албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлээгүй албан тушаалтанд хариуцлага тооцуулах саналыг хүргүүлээгүй байна.

### **2.2.3. Нийт зөрчлийн дийлэнх хувийг цалингийн тооцоолол, төсвийн хөрөнгийн үр ашигт байдалтай холбоотой зөрчил эзэлж байна.**

Дотоод аудитын дүрмийн 2 дахь хэсгийн 2.1-т “Дотоод аудитын үйл ажиллагаа нь хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгө, өр төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт шалгалт хийх, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангаж тухайн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад дэмжлэг үзүүлэхэд оршино” гэж заасан.

Санхүүгийн хяналт, аудитын албаны хяналт, шалгалтаар илэрсэн алдаа зөрчилд 1453 акт тогтоож, 63 албан шаардлага хүргүүлж, тухай бүх холбогдох албан тушаалтанд хэрэгжүүлж ажиллах арга хэмжээний санал, зөвлөмжийг хүргүүлсэн байна.

Хяналт шалгалтаар илэрсэн нийт алдаа зөрчлийг ангилан авч үзвэл дараах байдалтай байна. (График №3-4)



Тогтоосон актын дийлэнх буюу 47 хувийг цалингийн тооцоололтой холбоотой зөрчил эзэлж байна. Харин албан шаардлагын 57 хувийг арвилан хэмнэлт, үр ашиг, үр нөлөөтэй байдлыг сайжруулах чиглэлээр өгсөн байна.


Мөн шалгалтаар илэрсэн зөрчилд акт тогтоосноор 2015-2020 оны байдлаар нийт 820.2 сая төгрөгийг орон нутгийн төсвийн орлогын дансанд төвлөрүүлсэн байна.

### **Санал асуулга**

Аудитын явцад Санхүүгийн хяналт, аудитын албаны хяналт, шалгалтад хамрагдсан 27 байгууллагын удирдах албан тушаалтан, нягтлан бодогч, нярав болон шалгалтад хамрагдсан зарим алба хаагчдаас санал асуулга авав. Санал асуулгад 30 байгууллагын 45 хүн хамрагдсан.

Санал асуулгын дүнг нэгтгэн авч үзвэл дараах байдалтай байна.

График №5



Судалгаанаас харахад хяналт шалгалтыг аливаа нөлөөлөлд автаагүй, хараат бусаар, ёс зүйн зөрчилгүй, үр дүнтэй хэрэгжүүлсэн гэсэн хариултыг дийлэнх хэсэг нь өгсөн байна.

Мөн судалгаагаар цаашид анхаарах саналыг бичсэн байна. Үүнд:

#### **Хяналт шалгалтаар үүсдэг хүндрэлтэй асуудал хэсэгт:**

- Үйл ажиллагаанд бичиг цаасны ажлыг маш их нэмэгдүүлдэг
- Орон нутгийн үйл ажиллагаа, бодлого шийдвэртэй уялдуулдаггүй
- Хэт өндөр дүнтэй акт тогтоодог
- Санхүүгийн ажилчид тогтворгүй болсон
- Ажилчдын сэтгэл зүйд таагүй нөлөө үзүүлсэн
- Хяналтын ажил нь аудиторын үзэмжээс шалтгаалсан
- Зөрчилдөж байгаа хууль, журмаа танилцуулдаггүй
- Удирдамжид зааснаас бусад асуудлаар шалгадаг
- Хяналт, шалгалт нь акт, төлбөр тогтоох ажил дээр төвлөрдөг
- Тайландаа хувь хүний нэр төрд халддаг
- Нэг зөрчлийг 2-3 зөрчил болгож тайландаа бичдэг
- Санхүүгийн ажилчдыг хувь хүнийх нь хувьд, ёс зүйгүй харьцсан

#### **Хяналт шалгалтаар зөргээр нөлөөлсөн байдал хэсэгт:**

- Алдаа дутагдал хаана гарч байгааг мэддэг

- *Ажлын чанар үр дүн сайжирсан*
- *Хариуцлага нэмэгдсэн*
- *Эрсдэлээс сэргийлсэн*

**Бусад санал хэсэгт:**

- *Удирдлагуудын болон зарим зүйл зөрөлдөөнтэй байдаг*
- *Санхүүгийн үйл ажиллагаанд мөрдөх хууль, журмуудын талаар нэг ойлголттой болгох шаардлагатай байдаг*
- *Орон нутгийн үйл ажиллагаа, бодлого шийдвэртэй уялдуулах хэрэгтэй байдаг*
- *Зөвхөн цаасан дээр буусан ажлыг үнэлэхээ болих шаардлагатай байдаг*
- *Зөвлөн туслах ажил нь ач холбогдолтой байсан*
- *Төлөвлөгөөт хугацаандаа хяналтаа хэрэгжүүлж байх*
- *Сургалт, зөвлөгөө өгөх*
- *Эрсдэлээс сэргийлэх ажлыг үр дүнтэй хэрэгжүүлэх*
- *Шалгалтын үйл ажиллагааг үр дүнтэй гүйцэтгэх*
- *Санхүүгийн ажилчдыг чадваржуулах ажил хийх хэрэгтэй байдаг*
- *Үйл ажиллагааг нь тодорхой, ил тод болгох болгох*
- *Байгууллагын үйл ажиллагааг цаасаар биш цахимаар хэрэгжүүлэх арга барилтай болох*

Санал асуулгад хамрагдсан байгууллагуудаас ирүүлсэн зарим асуудлуудыг хяналт шалгалтын үйл ажиллагаандаа хэрэгжүүлэхэд анхаарч, хууль тогтоомжийн дагуу ажиллах нь зүйтэй юм.



**Холбогдох байгууллагын санал:**



**ДОРНОГОВЬ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГА**

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум, 3 дугаар баг,  
Нутгийн удирдлагын ордон, Утас: 7052 2533,  
Факс: (976) 7052 2530, И-мэйл: zdtg@dornogovi.gov.mn,  
Вэбсайт: dornogovi.gov.mn

2021. 11. 01 № 01/1341  
танай 2021. 10. 28 -ны № 4-6/560 -т

**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Т.ГАН-ӨЛЗИЙ ТАНАА**

Монгол Улсын Их хурлын Төсвийн байнгын хорооны 2020 оны 05 дугаар тогтоол, Ерөнхий аудиторын 2021 оны А/27 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө”, Үндэсний аудитын газрын нэгдсэн удирдамжаар “Төрийн байгууллагуудын дотоод аудитын тогтолцоо, чиг үүргийн хэрэгжилт” сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцсан бөгөөд тайлантай холбоотой санал байхгүй байна.



О.БАТЖАРГАЛ

44 6211449





ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, АУДИТЫН**

**АЛБА**

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,  
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,  
Утас: (705) 2-00-25, (705) 2-00-26  
И-мэйл: sankhuu\_audit\_dg@yahoo.com


2021.11.01 № 277  
танай 2021.10.28-ны № 16/569 -Т

ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Т.ГАН-ӨЛЗИЙ ТАНАА

Төрийн байгууллагуудын дотоод аудитын тогтолцоо, чиг үүргийн хэрэгжилт сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайлантай танилцлаа.

Гүйцэтгэлийн аудитын тайлантай холбоотой санал байхгүй болно.

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН  
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ, ДОТООД  
АУДИТОР Ж.БОЛОР-ЭРДЭНЭ



443210331

## ДҮГНЭЛТ:

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна.

- Дотоод аудитын эрх зүйн орчин бүрдсэн байна.
- Дотоод аудитын нэгж нь бие даасан даасан үйл ажиллагаа явуулах тогтолцоо бүрдсэн байна.
- Дотоод аудитын нэгжийн үйл ажиллагааны дүрэмд стандартын зарим шаардлага тусгагдаагүй, нэмэлт өөрчлөлт оруулаагүй байна.
- Дотоод аудитын нэгж нь чиг үүргээ хэрэгжүүлэх боломжтой бүтэцтэй, үйл ажиллагаа явуулахад шаардлагатай хөрөнгө бүрдсэн боловч мэргэжлийн хүний нөөцийн дутагдалтай байна.
- Дотоод аудитын нэгж нь хараат бусаар, хөндлөнгийн нөлөөлөлгүй ажил үүргээ гүйцэтгэх боломжтой байна.
- Зарим ажилчид дүрэмд заасан шалгуурыг хангаагүй байна.
- Санхүүгийн хяналт, дотоод аудитыг стандартад заасны дагуу төлөвлөөгүй, төлөвлөхөөс өмнөх болон төлөвлөх үе шатны ажлыг баримтжуулаагүй байна.
- Дотоод аудитын нэгжийн дунд хугацааны бодлогын баримт бичиг бүрэн хэрэгжээгүй байна.
- Нэгжийн зарим үйл ажиллагааг зохицуулах дүрэм, журам одоог хүртэл батлагдаагүй байна.
- Нэгжийн үйл ажиллагааг Facebook хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлж байна.
- Дотоод аудитын нэгж нь дүрэмд заасны дагуу санхүү, төсөв хариуцсан төрийн захиргааны төв байгууллага болон аймгийн ТЕЗ-тай уялдаатай ажиллаж байна.
- Эрх бүхий байгууллагаас дотоод аудитын нэгжийн үйл ажиллагаанд чанарын хяналтын үнэлгээг хийгээгүй байна.
- Шалгалтаар илэрсэн зөрчилд өгсөн зөвлөмж, албан шаардлага, тогтоосон төлбөрийн актын хэрэгжилт 89 хувьтай байна.
- Хяналт шалгалтын үр дүнд орон нутгийн төсвийн орлогод 820.2 сая төгрөгийг оруулсан байна.

Аудитаар алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх тухай 7 зөвлөмжийг 2 албан тушаалтанд хүргүүлээ.



### **ЗӨВЛӨМЖ:**

Аудитын дүн, дүгнэлт нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.Үүнд:

#### **АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА О.БАТЖАРГАЛ ТАНАА:**

1. Дотоод аудитын нэгжийн дүрмийг холбогдох стандартын шаардлагыг бүрэн тусгаж батлах.
2. "Орон нутагт дотоод аудитыг хөгжүүлэх дунд хугацааны стратеги"-ийн хэрэгжилтийг хангахад тодорхой ажил зохион байгуулж, анхаарч ажиллах.
3. Сангийн сайдтай хамтран ажиллах гэрээнд тусгасан дотоод аудитын нэгжийн үйл ажиллагаатай холбоотой заалтыг хэрэгжүүлэх.
4. Санхүүгийн хяналт, аудитын албаны шаардлага хангасан, мэргэжлийн хүний нөөцийг бүрдүүлэхэд хяналт тавьж ажиллах.

#### **АЙМГИЙН САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, АУДИТЫН АЛБАНЫ ДАРГА Х.ОЮУНТУЯА ТАНАА:**

1. Санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудитыг холбогдох стандартад заасны дагуу төлөвлөх, ажлын баримтыг тухай бүр баримтжуулж ажиллах.
2. Албан тушаалын тодорхойлолтыг хууль тогтоомжид заасан шалгуурыг бүрэн тусгаж, батлуулах.
3. Санхүүгийн хяналт, аудитын албаны шаардлага хангасан, мэргэжлийн хүний нөөцийг бүрдүүлэхэд анхаарч холбогдох арга хэмжээг авах.

#### **ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ УЛАМЖЛАХ НЬ:**

1. Дотоод аудитын нэгжээс акт тогтоох, албан шаардлага өгөх, хэрэгжилтийг тооцох болон байгууллагын үйл ажиллагааны мэдээ, тайлан гаргах журам боловсруулж ажиллахыг холбогдох эрх бүхий байгууллагад уламжилж өгнө үү.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.ГАН-ӨЛЗИЙ

**АУДИТЫГ ГҮЙЦЭТГЭСЭН БАГИЙН ГИШҮҮД:**

**ГҮЙЦЭТГЭСЭН:**

АУДИТОР

АУДИТОР



Б.УРАНБИЛЭГ



Л.РАВДАНДОРЖ

**ХЯНАСАН:**

АУДИТЫН МЕНЕЖЕР

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



У.ОЮУНТҮЛХҮҮР

Т.ГАН-ӨЛЗИЙ

АУДИТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХАМТРАН ОРОЛЦСОНД  
ТАЛАРХАЛ ИЛЭРХИЙЛБЕ.





**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН  
ТУШААЛ**

2021 оны 11 сарын 01 өдөр

Дугаар A/31

Дорноговь аймаг, Сайншанд сум

**Гүйцэтгэлийн аудитын тайлан  
баталгаажуулах тухай**

Монгол Улсын Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 9 дүгээр зүйлийн 9.1, 20 дугаар зүйлийн 20.1, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2018 оны А/207 дугаар “Эрх, үүрэг шилжүүлэх тухай” тушаалын 5 дугаар хавсралтын 1.3, 2.4, 2020 оны А/106 дугаар “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам” тушаалын 18.9, 2021 оны А/28 дугаар “Төрийн аудитын байгууллагын 2021 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө” тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Төрийн байгууллагуудын дотоод аудитын тогтолцоо, чиг үүргийн хэрэгжилт” сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайланг баталгаажуулсугай.

2. Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж, 2022 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлэхийг аймгийн Засаг дарга, Санхүүгийн хяналт, аудитын албаны дарга нарт зөвлөсүгэй.

3. Аудитын тайланг Үндэсний аудитын газар, аймгийн Засаг дарга, Санхүүгийн хяналт, аудитын албанд тус тус хүргүүлсүгэй.

4. Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер (У.Оюунтүлхүүр)-т даалгасугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.ГАН-ӨЛЗИЙ